



ЗАМ ТЭЭВРИЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Газрын дарга: С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 260512
Цахим хаяг:
oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Гэрэл
Утас: 263813
Цахим хаяг:
gerelts@audit.gov.mn

Монгол Улсын
Үндэсний аудитын газар
Улаанбаатар
Бага тойруу
Засгийн газрын IY байр
Цахим хуудас: www.audit.mn

Оршил
Санхүүгийн дотоод хяналт
Илрүүлсэн гол зүйлс,
гаргасан шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн
тайлан

Хавсралт 4: Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн
тайлан

Оршил

Зам тээврийн сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг танилцуулж байна.

Менежментийн захидалд санхүүгийн зарим үйл ажиллагааг сайжруулах талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан.

Ийнхүү хянахдаа байгууллагын дотоод хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Аудитаар дээд түвшний хяналтын асуудал хөндөгдсөн бөгөөд тэдгээрийг ЗТЯ-ын удирдлагын анхааралд хандуулж байна.

2013 онд Зам тээврийн сайдын төсвийн багцад урсгал зардал 24.5 тэрбум төгрөгөөр батлагдснаас 19.4 тэрбум төгрөг зарцуулж, 5.1 тэрбум төгрөгийн хэмнэлттэй ажилласан, 332.7 тэрбум төгрөгийн дотоодын хөрөнгө оруулалтын төсөв батлагдаж, 260.7 тэрбум төгрөг буюу 78.3 хувийг зарцуулж, 72.0 тэрбум төгрөгийг зарцуулаагүй улсын төсөвт үлдсэн байна.

Мөн 2013 онд 122.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг гадаадын зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 231.2 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих барилгын ажлын гэрээг батлуулах ажил 2008 онд эхэлсэн боловч хугацаа нь сунжирч, 2013 оны 6 сард батлагдсан, уг төсөлд УИХ-аас 2012 онд 10.4 тэрбум, 2013 онд 31.2 тэрбум төгрөгийн зээлээр санхүүжихээр баталсан бөгөөд дээрх олон улсын гэрээний нөхцлийн дагуу 2013 онд 166.1 тэрбум төгрөгтэй тэнцэх иений зээлийн эрх нээгдэж, санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Сайдын төсвийн багцад хамаарах 40 нэгжээс аудитад хамрагдсан 29, үүнээс дүгнэлт гарсан 27, түүвэрт хамрагдсан 2 байна. Аудитын дүгнэлт гарсан 27 тайлангийн хувьд зөрчилгүй 23, хязгаарлалттай 4 тайлан, үүнд ИНЕГ, Төлбөр хураах цэг, Увс, Орхон аймгуудын Тээвэр авто замын газрууд орж байна.

Олон улсын байгууллагын санхүүжилттэй 9 төслийн санхүүгийн тайланд аудит хийх компанийг сонгон шалгаруулаагүй, Хэнтий аймгийн Тээвэр автозамын газар санхүүгийн тайлангаа хугацаа хоцроож төрийн аудитын байууллагад ирүүлсэн шалтгаанаар тус тус аудит хийгдээгүй байна.

Зам тэврийн сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийгдсэн зарим байгууллагын дүнг харуулбал,

1.Зам тэврийн яамны аппарат:

2013 оны санхүүгийн тайланд ҮАГ аудит хийж, зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна. Тус яам 2013 онд 4,191.5 сая төгрөгийн төсөв батлагдсан, гүйцэтгэлээр 3,617.6 сая төгрөг зарцуулсан байна.

Аудитын явцад 3,989.5 сая төгрөгийн 2 төрлийн алдаа залруулж, нийт 7,341.5 сая төгрөгийн асуудалд хамаарах 2 зөвлөмж өгч, УБТЗ ХНН-т түрээслүүлсэн тоног төхөөрөмжийн 2012, 2013 оны түрээсийн төлбөр 399.6 сая төгрөгийг нэхэмжилж оруулаагүйд төлбөрийн акт тогтоолоо.

2.Автозамын сан:

2013 оны санхүүгийн тайланд ҮАГ аудит хийж, зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна. 2013 онд зам, замын байгууламжийн засвар арчлалтын зардалд 19,000.0 сая төгрөгийн төсөв батлагдсан, гүйцэтгэлээр 15,743.1 сая төгрөг зарцуулсан байна.

2006-2007 онд үүссэн 27 байгууллага, аж ахуйн нэгжид хамаарах 2,794.3 сая төгрөгийн авлага, 18 байгууллага, аж ахуйн нэгжид хамаарах 236.3 сая, мөн "хяналтын зардлын өглөг" нэрээр балансад тусгагдсан байгууллагын нэргүй 315.4 сая, нийт 551.7 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй байгаа нь тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, эзэн холбогдогч нь нэхэмжилдэггүй байна.

2000 онд "Мянганы зам" төсөл хэрэгжиж байх үед ХХБ-д нээсэн долларын харилцахад 6854 ам. долларын үлдэгдэл байсныг төлбөрийн акт тогтоож, төсвийн орлого болгосон ба уг дансыг хаах зөвлөмж өглөө.

3.Иргэний нисэхийн ерөнхий газар:

ИНЕГ-ын 2013 оны санхүүгийн тайлангийн аудитыг ҮАГ хийж, "хязгаарлалттай" санал дүгнэлт өгсөн байна. Энэ нь:

- Нэг удаагийн тэтгэмжийн зардлаас ахмадуудад сар бүр 30.0 мянган төгрөгөөр тооцож, нийт 265 ахмадад 231.4 сая төгрөг олгосон,
- Цалингийн давхардал үүсгэн хүүхэд асарч байгаа нэг эхэд сар бүр үндсэн цалингийн 70 хувиар тооцон 87 эхэд 267.2 сая төгрөгийн тэтгэмж олгосон,
- ИНЕГ-ын 2012 оны санхүүгийн аудитаар илэрсэн зөрчилд ҮАГ-аас 540.0 сая төгрөгийн төлбөрийн акт тавьсан боловч барагдуулаагүй,
- "SABO" институттэй байгуулсан гэрээний дагуу 2012 онд шилжүүлсэн урьдчилгаа төлбөрөөс 2013 онд 315.2 сая төгрөгийг сургалтын зардлаар тооцож бүртгэсэн боловч тооцоо нийлж баталгаажуулаагүй,
- Гадаадын авиа компаниудаас авах 7,400.6 сая, гадны байгууллагаас авах 206.7 сая, нийт 7,607.3 сая төгрөгийн авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүйтэй холбоотой байна.

Аудитаар нийт 8,388.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэний 7,458.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 5 зөвлөмж өгөгдсөн байна.

Тус газар 2013 онд урсгал зардалд 87.8 тэрбум төгрөгийн зардлын төлөвлөгөө батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 85.7 тэрбум төгрөг зарцуулсан нь дүнгээрээ 2.1 тэрбум төгрөгийн хэмнэлттэй байна. Гэвч зардлын зүйл ангиар нь авч үзвэл захиалгат нислэгийн зардал 204.9 сая, нэг удаагийн буцалтгүй тусламж 77.1 сая, хоолны хөнгөлөлт 58.6 сая, сэлбэг хэрэгсэл 41.8 сая, эмчилгээний дэмжлэг 32.6 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна. Үүний дотор Үл хөдлөх хөрөнгийн татварт 583,8 сая төгрөг батлагдсан ба гүйцэтгэлээр 688,8 сая төгрөг зарцуулж 105,0 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

4. Автозамын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төв:

Тус газрын 2013 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Дөлгөөнхайрхан-Уул аудит” ХХК хийж, “зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

2013 онд улсын төсвөөс 1,003.3 сая төгрөгийн санхүүжилт авахаар батлагдсанаас 981.7 сая төгрөг зарцуулж, үндсэн үйл ажиллагаа болох лабораторийн шинжилгээ болон замын хяналтаас 1,978.1 сая төгрөгийн орлого оруулж төсөвт төвлөрүүлэхээр баталснаас 2,200.4 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Мөн туслах үйл ажиллагаа болох төлөвлөөгүй захиалагчийн хяналт тавьснаас 238.6 сая төгрөгийн орлого олж, түүнээс 82.0 сая төгрөг зарцуулж, нэмэлт санхүүжилтийн дансанд 156.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

5. Төлбөр хураах цэг:

Тус газрын 2013 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Дөлгөөнхайрхан-Уул аудит” ХХК хийж, “хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна. Энэ нь албан томилолтын болон цалин хөлс, түүнтэй холбогдох зардлыг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн сууриар бүртгэсэн, Төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан маягтын дагуу бэлтгээгүй, АЗХЭШСТ-ийн захирлын 2013 оны Б/177 дугаар тушаалаар нэр бүхий 31 ажилтанд 16.4 сая төгрөгийн урамшуулал давхардуулан олгосонтой холбоотой байна.

Тус байгууллага 2013 онд олон улсын болон улсын чанартай авто зам ашигласны төлбөр хураамжийн 862.8 сая төгрөгийн орлого оруулах төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,300.4 сая төгрөг оруулж, 826.1 сая төгрөг зарцуулсан дүнтэй байна. Төлбөр хураах цэгийн 2013 оны санхүүгийн тайланд хийсэн явцын аудитаар 2, жилийн эцсийн аудитаар 3 зөвлөмж өгсөн байна.

6. Тээврийн үндэсний төв УТҮГ:

“Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт, зохицуулалтын алба”-ыг Засгийн газрын 2013 оны 27 дугаар тогтоолоор “Автотээврийн үндэсний төв” УТҮГ болгон зохион байгуулсан байна. Тус байгууллагын 2013 оны санхүүгийн тайлангийн аудитыг СМД-Аудит ХХК хийж, “зөрчилгүй” санал дүгнэлт гаргасан байна.

Тус байгууллага 2013 онд улсын төсвөөс 5,719.4 сая төгрөгийн санхүүжилт авахаар баталж, гүйцэтгэлээр 5,640.7 сая төгрөг зарцуулсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого болох оношлогоо, улс хоорондын тээврийн 10.0 хувь, хот хоорондын тээврийн орлогын 8.0 хувь, автомашины тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний гэрчилгээ олголтоос 15,028.4 сая төгрөг оруулж, улсын төсөвт 7,054.4 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Үндсэн бус үйл ажиллагааны орлогоор бүртгэгдсэн 15,534.3 сая төгрөг нь автовокзалын кассад орсон зорчигч тээврийн хөлсний 8.0 хувийг авч үлдэн, 92 хувийг аж ахуйн нэгжүүдэд буцаан шилжүүлж өгдөг.

7. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв:

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2013 оны санхүүгийн тайланд тусгагдсан зарим гүйлгээг ҮАГ-аас түүвэрчлэн шалгахад зөрчил илэрсэнгүй. Тус байгууллага 464.8 сая төгрөгийн төсөв батлагдснаас 412.7 сая төгрөг зарцуулсан байна.

8. Орхон аймгийн Тээвэр автозамын газар:

Тус газрын 2013 оны санхүүгийн тайлангийн аудитыг Орхон аймгийн аудитын газар гүйцэтгэж, “хязгаарлалттай” санал дүгнэлт гаргасан байна. 2013 оны санхүүгийн тайланг 2014 оны 2 дугаар сарын 22-ны өдөр төрийн аудитын байгууллагад ирүүлсэн нь хугацааны хувьд ажил гүйлгээг шалгах, ажиглалт хийх замаар хангалттай нотлох зүйл олж авах нөхцөл бүрдээгүй тул санал дүгнэлтээ хязгаарлахад хүргэсэн байна.

9. Увс аймгийн Тээвэр автозамын газар:

Тус газрын 2013 оны санхүүгийн тайлангийн аудитыг Увс аймгийн Аудитын газар гүйцэтгэж, “хязгаарлалттай” санал дүгнэлт гаргасан байна. 2013 онд нийт 130.3 сая төгрөгийн төсөв зарцуулснаас цалингийн зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлтөд 2.6 сая, шагналд 0.3 сая төгрөг олгож батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулан тайлагнасан асуудлаар зөвлөмж өгсөн байна.

10. Монгол Улсын Далайн захиргаа УТҮГ:

МУ-ын Далайн захиргааны 2013 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Алтанжолоо-Аудит” ХХК гүйцэтгэж, зөрчилгүй санал дүгнэлт гаргасан байна. Тус байгууллагад 2013 онд 624.3 сая төгрөг зарцуулахаар яамнаас баталсан бөгөөд гүйцэтгэлээр 523.6 сая төгрөг буюу 84.0 хувийг зарцуулсан байна.

“Монголын хөлөг онгоцны бүртгэл” ХК-иас хөлөг онгоцны бүртгэлээс 310.5 сая төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 320.5 сая, бусад орлогоор 203.1 сая төгрөг орсон байна. Дээрх компаниас сар бүрийн үйл ажиллагааны зардлаа нэхэмжилдэг боловч 1-2 сараар хоцорч орж ирдэг нь байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй байх тул уг асуудлаар зөвлөмж өгсөн байна.

11. Зам тээврийн салбарын хөрөнгө оруулалт:

2013 оны төсвийн багцад 332,753.9 сая төгрөгийн дотоодын хөрөнгө оруулалтын төсөв батлагдаж, 260,706.5 сая төгрөг буюу 78.3 хувийг зарцуулж, 72,047.3 сая төгрөгийг зарцуулаагүй үлдсэн байна.

Зам тээврийн сайдын төсвийн багцын хэмжээгээр 2012 онд нийт 15 төсөл хэрэгжихээр батлагдснаас 9 төсөл үйл ажиллагаа явуулж, УИХ-аас батлагдсан төлөвлөгөөгөөр 2013 онд 122.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг гадаадын зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Төсвийн гүйцэтгэлээр дээрх 9 төслийн барилгын ажил, зөвлөхийн үйлчилгээ болон бараа үйлчилгээний ҮАГ-САГ/2014/07/СТА-ТЕЗ

зардал олон улсын гэрээний нөхцөл ёсоор гадаадын зээлийн эх үүсвэрээс нийт 231.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс Улсын комиссын актыг үндэслэн 32,109.5 сая, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс 76,943.8 сая, нийт 109,053.3 сая төгрөгийн хатуу хучилттай авто зам болон төмөр бетон гүүрийг “Дуусаагүй барилга” данснаас хасч үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн байна.

2013 онд дууссан боловч Улсын комисс хүлээн аваагүй авто зам болон гүүрийн 176,773.7 сая, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн авто замын төсөл, арга хэмжээний 614,342.8 сая, нийт 791,116.5 сая төгрөгөөр “Дуусаагүй барилга” дансыг нэмэгдүүлсэн байна.

Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд:

Аудитаар нийт 436.6 сая төгрөгийн зөрчилд 11 акт тогтоогдсон, 7,459.8 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага бичигдсэн, 8,349.3 сая төгрөгийн зөрчилд 32 зөвлөмж өгөгдсөн, 4,033.0 сая төгрөгийн 16 алдаанд залруулга хийгдсэн байна.

- Арвайхээр-Баянхонгор-Алтайн чиглэлийн зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлын гүйцэтгэгч Номгон хайрхан ХХК 2012 оноос гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, аймаг орон нутгаас энэ асуудлыг удаа дараа тус яаманд тавьсаар байхад 2013 оны эхэнд 473.3 сая төгрөгийн гэрээ шинээр байгуулж 134.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон байна.
- Улмаар ажлаа хийгээгүйгээс гэрээ цуцалж шүүхэд хандсан боловч захирал нь олдохгүй шалтгаанаар шийдэгдээгүй, авлага үүссэн байна.
- Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэсэн заалтууд хангагдахгүй байна.
- Цаашид ийм хариуцлагагүй байдлыг давтан гаргахгүй талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.
- Хөгжлийн банкны санхүүжилтээр баригдаж буй зам, гүүрийн гүйцэтгэгчдэд олгосон санхүүжилтийн хэмжээгээр 2 төсөл арга хэмжээний 76,943.8 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө, 614,342.8 сая төгрөгөөр “Дуусаагүй барилга” дансанд тус тус хандивын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Дээрх орлогоос шалтгаалж сайдын багцын тайлант оны үр дүн 1,111.1 сая төгрөгт хүрсэн байна.
- Хөгжлийн банк, Зам тээврийн яам, гүйцэтгэгч хооронд байгуулсан гурвалсан гэрээний дагуу тус яам гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд хамааралгүй, зөвхөн захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байна. Гэтэл гэрээний хариуцлага хэсэгт “...аливаа шалтгаанаар ажил зогсох, гэрээ цуцалснаас үүдэн гарах хариуцлагыг санхүүжүүлэгч хариуцахгүй” гэсэн нь

цаашид гүйцэтгэгчийн хариуцлагаас шалтгаалсан эрсдэл үүрч болзошгүй байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Зам тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ҮАГ-аас хийсэн аудитаар Төсвийн тухай хуулийн 6.4.1-д: “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг мөрдөж ажиллах, автозамын сангийн хуульд заасан эх үүсвэрүүдийг бүрэн төвлөрүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх, ИНЕГ-ын навигацийн даатгалын компанийг хуулийн дагуу тендер зарлаж сонгож байх талаар нийт 3 зөвлөмж өгөгдсөн байна.

Зөвлөмжийн биелэлтийг гаргаж, ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 3/4744 дүгээр албан бичгээр ҮАГ-т ирүүлсэн байна. Автозамын сангийн хуульд заасан эх үүсвэрийн асуудлаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлсэн, бусад зөвлөмжид тодорхой арга хэмжээ авч ажилласан байна.

Аудитын санал дүгнэлт

Бид Зам тээврийн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна” гэсэн “**зөрчилгүй**” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

**ЗАМ ТЭЭВРИЙН САЙД
А. ГАНСҮХ ТАНАА**

№ _____
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам тээврийн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Зам тээврийн яамны удирдлага Төсвийн тухай хуульд заасны дагуу тайланг хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Зам тээврийн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

070474



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Зам тээврийн сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1: Авлага

Асуудал 2: Хөгжлийн банкны санхүүжилт

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг ЗТЯ-ны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь ЗТЯ-ны хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг илрүүлэх боломжгүй юм.

Иймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батзаяа, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга З.Цэрэнчимэг тайлангийн нэгтгэл хариуцсан мэргэжилтэн .Алтангэрэл нар болон санхүүгийн бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

Арвайхээр-Баянхонгор-Алтайн чиглэлийн зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлын гүйцэтгэгч Номгон хайрхан ХХК 2012 оноос гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, аймаг орон нутгаас энэ асуудлыг удаа дараа тус яаманд тавьсаар байхад 2013 оны эхэнд 473.3 сая төгрөгийн гэрээ шинээр байгуулж 134.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон байна.

Улмаар ажлаа хийгээгүйгээс гэрээ цуцалж шүүхэд хандсан боловч захирал нь олдохгүй шалтгаанаар шийдэгдээгүй, авлага үүссэн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах, тус компаниас авлага барагдуулах арга хэмжээ авах;

Эрсдэлүүд

Авлага найдваргүй болох эрсдэл,
/Т, Э, Ү/

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлд тусган танилцуулж, зөвшөөрүүлсэн.

ҮАГ-ын ажиглалт

Хөгжлийн банкны санхүүжилтээр баригдаж буй зам, гүүрийн гүйцэтгэгчдэд олгосон санхүүжилтийн хэмжээгээр 2 төсөл арга хэмжээний 76,943.8 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө, 614,342.8 сая төгрөгөөр “Дуусаагүй барилга” дансанд тус тус хандивын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Дээрх орлогоос шалтгаалж сайдын багцын тайлант оны үр дүн 1,111.1 сая төгрөгт хүрсэн байна.

Хөгжлийн банк, Зам тээврийн яам, гүйцэтгэгч хооронд байгуулсан гурвалсан гэрээний дагуу тус яам гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд хамааралгүй, зөвхөн захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байна. Гэтэл гэрээний хариуцлага хэсэгт” аливаа шалтгаанаар ажил зогсох, гэрээ цуцалснаас үүдэн гарах хариуцлагыг санхүүжүүлэгч хариуцахгүй” гэсэн нь цаашид гүйцэтгэгчийн хариуцлагаас шалтгаалсан эрсдэл үүрч болзошгүй байна.

Эрсдэлүүд

Зээлийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдах.
/Үнэн зөв/

ҮАГ-ын зөвлөмж

Ирээдүйд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж , зохих хяналтыг эрчимжүүлж ажиллах,

Үйлчлүүлэгчийн хариу

Ажлын хэсэг гарч гэрээний загварт өөрчлөлт оруулах ажил хийгдэж байна.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,799,731,183.77	37,482,405,196.70
Кассанд байгаа бэлэн мөнгө	58,211,325.55	44,151,174.09
Төгрөг\ ЖМС	55,532,189.67	43,383,671.69
Гадаад валют	2,679,135.88	767,502.40
Банкинд байгаа бэлэн мөнгө	14,741,519,858.22	37,438,254,022.61
Төгрөг	11,713,013,227.94	37,438,254,022.61
Төсөвт байгууллагын харилцах	10,225,058,117.82	21,070,343,108.97
Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк)	1,487,955,110.12	12,809,132,199.84
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	3,558,778,713.80
Гадаад валют	3,028,506,630.28	-
Тусгай зориулалтын сангийн харилцах	3,028,506,630.28	-
АВЛАГА	40,888,793,888.97	44,850,319,170.18
Ажиллагчидтай холбогдсон авлага	40,048,545.91	2,991,220.24
Төлбөртэй үйлчилгээний авлага	25,019,713,142.41	27,047,170,011.52
Татаас, санхүүжилт, (бүтээгдэхүүн нийлүүлэлтийн) авлага	2,540,637,411.80	-
Бусад авлага	13,288,394,788.85	17,800,157,938.42
Байгууллагаас авах авлага	13,237,080,601.14	17,741,165,175.17
Түлш халаалтын авлага	1,271,396.00	-
Дотоод албан томилолтын авлага	65,600.00	-
Урсгал засварын авлага	6,543,920.00	-
Бусад зардлын тооцооны авлага	13,229,199,685.14	17,741,165,175.17
Хувь хүмүүсээс авах авлага	51,314,187.71	58,992,763.25
УРЬДЧИЛГАА	99,109,415,377.43	63,139,413,491.26
Бусад урьдчилгаа	99,109,415,377.43	63,139,413,491.26
Урьдчилгаа тооцоо	12,595,554.29	5,500,000.00
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	12,595,554.29	5,500,000.00
Урьдчилж гарсан зардал	99,096,819,823.14	63,133,913,491.26
Урьдчилж төлсөн зардал	99,096,819,823.14	63,133,913,491.26
БАРАА МАТЕРИАЛ	276,755,195,601.36	7,123,222,513.22
Түүхий эд материал	269,680,278,749.42	6,027,272.00
Тусгай зориулалттай материал	107,535,519.10	5,410,845.00
Дуусаагүй үйлдвэрлэл	269,572,252,064.82	-
Бэлэн бүтээгдэхүүн	491,165.50	616,427.00
Хангамжийн материал	7,041,590,293.09	7,079,480,031.37
Бичиг хэргийн материал	74,083,539.40	97,243,699.23
Аж ахуйн материал	6,285,016,285.28	6,852,418,811.73
Сэлбэг хэрэгсэл	348,352,574.50	13,281,594.60
Түлш, шатах тослох материал	15,739,827.82	8,342,097.29
Барилгын засварын материал	2,081,910.00	2,797,070.00
Хүнсний материал	1,202,000.00	661,600.00
Бусад бараа материал	315,114,156.09	104,735,158.52
Мал амьтад	9,281,938.66	8,731,938.66
Бусад	24,044,620.19	28,983,271.19
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	431,553,136,051.53	152,595,360,371.36
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	671,821,966,669.80	2,060,015,284,273.25
Биет хөрөнгө	669,412,066,079.51	2,057,635,131,387.96
Барилга, байгууламж, орон сууц	106,471,095,165.44	103,948,003,381.97
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	155,086,759,342.81	157,413,597,022.39

Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(48,615,664,177.37)	(53,465,593,640.42)
Авто-тээврийн хэрэгсэл	8,247,467,682.30	6,820,691,554.82
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	23,427,235,228.10	21,922,265,830.36
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(15,179,767,545.80)	(15,101,574,275.54)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	42,540,339,375.86	46,843,749,950.42
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	96,792,845,343.74	99,773,425,515.79
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(54,252,505,967.88)	(52,929,675,565.37)
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,913,092,305.90	2,550,400,857.16
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	6,365,672,086.51	6,140,312,409.10
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(3,452,579,780.61)	(3,589,911,551.94)
Зам, гүүрийн байгууламж	340,372,247,461.54	428,481,673,877.46
Зам, гүүрийн байгууламж - Анхны өртөг	957,987,535,985.45	1,070,380,461,249.84
Зам, гүүрийн байгууламж - Хуримтлагдсан элэгдэл	(617,615,288,523.91)	(641,898,787,372.38)
Бусад үндсэн хөрөнгө	169,645,941.50	24,305,773.87
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	210,464,502.00	38,223,142.00
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(41,890,560.50)	(17,924,368.13)
Номын фонд	1,072,000.00	4,007,000.00
Дуусаагүй барилга, байгууламж	168,698,178,146.97	1,468,966,305,992.26
Биет бус хөрөнгө	2,409,900,590.29	2,380,152,885.29
Програм хангамж	2,409,622,468.64	2,379,927,263.68
Програм хангамж - Анхны өртөг	4,350,055,205.21	5,164,398,359.29
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(1,940,432,736.57)	(2,784,471,095.61)
Бусад биет бус хөрөнгө	278,121.65	225,621.61
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	450,000.00	450,000.00
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(171,878.35)	(224,378.39)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,103,375,102,721.33	2,212,610,644,644.61
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,302,308,004.57	24,537,055,009.08
Өглөг	13,287,876,952.57	24,522,093,982.45
Ажилчидтай холбогдсон тооцоо	40,601,038.18	81,581,803.67
Цалингийн өглөг	15,032,691.45	10.00
НДШ-ийн өглөг	8,181,349.02	15,962,409.77
ХАОАТ-ын өглөг	17,386,997.71	65,592,040.90
ҮЭ-ийн өглөг	-	27,343.00
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	901,241.00	15,114,061.60
Гэрэл цахилгааны тооцоо	6,082.00	-
Түлш халаалтын тооцоо	471,741.00	2,412,984.00
Шуудан холбооны тооцоо	223.00	241,729.60
Тээвэр шатахуунын тооцоо	340,000.00	2,390,258.00
Байрны түрээсийн тооцоо	23,900.00	2,000,000.00
Байрны засварын тооцоо	-	431,120.00
Бусад зардлын тооцоо	59,295.00	7,637,970.00
Бусад өглөг	13,246,374,673.39	24,425,398,117.18
Байгууллагад төлөх өглөг	13,245,686,711.18	24,418,795,060.10
Хувь хүмүүст төлөх өглөг	687,962.21	6,603,057.08
Урьдчилж орсон орлого	14,431,052.00	14,961,026.63
Төсөвт байгууллага	14,430,852.00	14,961,026.63
Урьдчилж орсон орлого	14,430,852.00	14,961,026.63
Бусад урьдчилж орсон орлого	200.00	-
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР	17,178,695,475.51	7,193,094,698.38
Урт хугацаат зээл	17,178,695,475.51	7,193,094,698.38
Гадаад валют	17,178,695,475.51	7,193,094,698.38
Гадаадын Засгийн газраас	5,250,604,575.57	-
Олон улсын санхүүгийн байгууллагаас	11,928,090,899.94	7,193,094,698.38

Төслийн зээл	11,928,090,899.94	7,193,094,698.38
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	30,481,003,480.08	31,730,149,707.46
Засгийн газрын хувь оролцоо	1,072,894,099,241.25	2,180,880,494,937.15
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	514,451,622,808.55	574,847,614,462.39
Хуримтлагдсан үр дүн	431,656,617,059.61	1,479,386,601,687.14
Өмнөх үеийн үр дүн	431,656,617,059.61	368,204,655,302.06
Тайлант үеийн үр дүн	-	1,111,181,946,385.08
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	126,785,859,373.09	126,646,278,787.62
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,072,894,099,241.25	2,180,880,494,937.15
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,103,375,102,721.33	2,212,610,644,644.61

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	450,848,609,278.61	638,505,462,093.51
Олон улсын байгууллагын тусламж	12,729,047,283.00	41,329,341,957.14
Урсгал тусламж	495,310,607.38	297,299,371.37
Хөрөнгийн тусламж	12,233,736,675.62	41,032,042,585.77
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	438,119,561,995.61	597,176,120,136.37
Улсын төвлөрсөн төсвөөс	364,706,885,826.08	320,084,146,495.81
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	16,806,473,047.08	17,476,342,220.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	107,975,000.00	219,000,000.00
Хөрөнгийн	347,792,437,779.00	289,527,519,442.21
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	12,861,284,833.60
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	51,046,970.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төөвөөс доод шатны төсвийн захи	-	15,700,565.83
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	11,280,884,328.77
Төсвийн урамшуулал	-	1,513,652,969.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	441,998,761.00	449,217,143.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	302,101,150.00	96,566,700.00
Хөрөнгийн	139,897,611.00	352,650,443.00
Төсөвт байгууллагаас	14,946,099,353.00	45,307,054,420.46
Өр барагдуулах санхүүжилтийн орлого	10,000,000.00	39,050,572,267.64
ТЕЗ-аас олгосон санхүүжилт	14,936,099,353.00	6,256,482,152.82
Нийгмийн даатгалын сангаас	5,881,781.00	35,074,868.00
НДС-ийн шилжүүлэг	1,139,358.00	35,074,868.00
ЭМДС-ийн шилжүүлэг	4,742,423.00	-
Бусад Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	58,018,696,274.53	231,300,627,209.10
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	-	2,781,200.00
Замын санд олгох татаас	5,400,000.00	-
Гадаад төслийн зээлээс санхүүжих	54,901,539,336.18	231,297,846,009.10
Тодорхойгүй орлого	3,111,756,938.35	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	136,003,016,362.88	857,550,671,537.82
Өмчийн орлого	2,432,176.00	11,806,091.50
Хүүгийн орлого	-	11,806,091.50
Түрээсийн орлого	2,432,176.00	-
Төрийн өмч түрээслүүлсний орлого	2,432,176.00	-
Бараа, үйлчилгээний борлуулалт	136,000,468,186.88	857,521,565,446.32
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	18,450,992,680.61	715,694,315,824.09
Үндсэн үйл ажиллагааны орлого	15,460,720,267.67	19,761,497,761.43
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	2,930,346,874.78	655,325,252,376.80
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	59,925,538.16	40,607,565,685.86
Навигацийн орлого	117,549,475,506.27	141,827,249,622.23
Торгууль, шимтгэл	116,000.00	-
Татварын бус бусад орлого	-	17,300,000.00
Хөрөнгийн орлого	-	17,300,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	586,851,625,641.49	1,496,056,133,631.33
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	42,129,423,921.10	48,446,862,122.64
Үндсэн болон нэмэгдэл цалин	38,021,809,276.48	43,726,636,070.61
Үндсэн цалин	34,874,575,098.17	39,211,993,797.49

Гэрээт ажилчдын цалин	942,788,907.98	1,830,040,884.56
Унаа хоолны хөнгөлөлт	80,877,458.79	2,657,784,745.56
Бусад нэмэгдлүүд	2,123,567,811.54	26,816,643.00
Унаа, болон бусад нөхөн олговор	2,111,552,130.04	4,302,000.00
Бусад нэмэгдэл	12,015,681.50	22,514,643.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	4,107,614,644.62	4,720,226,052.03
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	3,295,297,118.00	3,951,774,782.54
Тэтгэврийн даатгалын шимтгэл	2,559,058,154.13	3,131,758,670.33
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	261,260,091.10	333,790,310.13
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	376,122,999.31	394,789,758.17
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	98,855,873.46	91,436,043.91
Эрүүл мэндийн даатгалын хураамж	812,317,526.62	768,451,269.49
УРСГАЛ ЗАРДАЛ	76,919,394,968.93	78,428,970,613.83
Бараа үйлчилгээний урсгал зардал	72,603,184,383.30	66,064,927,164.60
Тогтмол зардал	1,882,206,381.54	2,081,745,636.23
Гэрэл цахилгаан	1,006,075,792.37	1,097,488,473.95
Түлш, халаалт	774,633,836.71	844,110,472.14
Цэвэр, бохир ус	101,496,752.46	140,146,690.14
Бусад бараа үйлчилгээний зардал	70,720,978,001.76	63,983,181,528.37
Бичиг хэргийн зардал	474,071,593.03	464,127,552.28
Тээвэр, шатахуун	3,778,784,985.38	3,708,615,974.03
Шуудан, харилцаа холбоо	1,693,852,915.83	212,231,321.94
Дотоод албан томилолт	1,104,488,705.85	1,085,929,132.75
Гадаад албан томилолт	837,673,181.42	385,355,801.30
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	17,115,326.00	24,692,740.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	3,101,139,605.33	3,291,443,092.97
Сургалт семинарын зардал	104,245,454.50	18,979,208.24
Эрдэм шинжилгээний ажил хийх	850,000.00	7,851,192.50
Жижиг эд хогшил худалдан авах	966,786,538.02	228,648,776.63
Жижиг эд хогшил худалдан авах \Багаж хэрэгсэл\	15,128,700.00	31,856,820.00
Жижиг эд хогшил худалдан авах \Тавилга\	113,856,299.18	43,001,700.00
Жижиг эд хогшил худалдан авах \Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл\	666,821,760.27	19,690,070.17
Жижиг эд хогшил худалдан авах \Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс\	147,565,228.57	90,882,826.46
Жижиг эд хогшил худалдан авах \Програм хангамж\	23,414,550.00	43,217,360.00
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	198,098,195.61	973,919,103.90
Төлбөр хураамж, жижиг татварууд	1,924,604,372.17	5,028,753,487.43
Харуул, хамгаалалтын зардал	191,470,624.37	1,530,400.00
Банкны үйлчилгээний хураамж	23,360,260.88	30,986,035.35
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	8,759,327,175.68	2,884,973,178.86
ТӨГАҮ \Нийтэд үйлчилгээ үзүүлэх Засгийн газрын бус байгууллагад Нормативаар тоо\	1,403,000.00	-
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	6,624,801,930.21	1,799,069,950.86
ТӨГАҮ \Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (гадаад) \	15,339,997.36	72,000.00
ТӨГАҮ \Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (дотоод) \	5,801,200.00	2,370,000.00
ТӨГАҮ \Эд хөрөнгийн даатгал\	1,988,519,537.40	1,080,593,506.00
